



Олон улсын Герман хэлний олимпиадын урьдчилсан шалгаруулалт болох Герман хэлний үндэсний олимпиадын (NDO) удирдамж 2026

Оршил

Герман хэлний үндэсний олимпиад (NDO) нь **2026 оны 7-р сарын 13-22-нд Маннхайм** хотод зохион байгуулагдах Герман Хэлний Олон Улсын Олимпиад (IDO)-ын урьдчилсан шатны шалгаруулалт юм. Энэ жилийн уриа: **„DABEI SEIN! ZusammenWachsen“**. Тус олимпиадад 14-17 насны, Герман хэлийг гадаад хэлээр сурч буй сурагчид оролцох боломжтой.

Урьдчилсан шалгаруулалтад түрүүлсэн хоёр сурагч Goethe-Institut-ийн бүрэн тэтгэлэг авч, Маннхайм хотод болох IDO-д Монгол Улсаа төлөөлөн оролцоно. Тэтгэлэгт нислэгийн зардал, олимпиадын хөтөлбөр, сургалтын төлбөр, хоол, хармааны мөнгө, ослын болон эрүүл мэндийн суурь даатгал багтана.

IDO гэж юу вэ?

Герман Хэлний Олон Улсын Олимпиад (IDO) нь **дэлхий даяарх герман хэл суралцагчдын дунд зохион байгуулагддаг хамгийн том тэмцээн юм.**

Хоёр жил тутамд Германд байрлах аль нэгэн салбар Goethe-Institut хариуцан зохион байгуулдаг бөгөөд 50 гаруй орны шилдэг сурагчдыг нэг дор цуглуулдаг. Энд хуран цугласан хүүхэд, өсвөр үеийнхнийг энэ удаа ч бас урлаг соёлын үйл ажиллагаа, Workshop-ууд, хоттой танилцах, орон орны үе тэнгийн хүүхэд залуустай уулзах гээд олон сонирхолтой хөтөлбөр хүлээж байна.



Оролцогчдын тоо

Сургууль бүр түвшин бүрт тус бүр нэг сурагчийг эцсийн шатанд оролцуулна.

Хэлний түвшин

Урьдчилсан шалгаруулалт GER буюу Европын хэлний нэгдсэн стандартын A2 болон B1 түвшинд зохион байгуулагдана.

Оролцогчдод тавих шаардлага

- IDO 2026-ийн үеэр (2026.07.13–22) хамгийн багадаа 14, хамгийн ихдээ 17 настай байх,
→ Өөрөөр хэлбэл: 2008.07.24/25–2012.07.11/12 хооронд төрсөн байх (улсын цагийн бүсээс хамаарна)
- Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн сурагч байх
- NDO-ийн эцсийн шатанд (2026.03.14) заавал оролцох боломжтой байх

Шударга байх зарчмын үүднээс дараах нөхцөлд олимпиадад оролцуулах боломжгүй. Үүнд:

- **A2 түвшинд:** B1 түвшний шалгалт өгсөн эсвэл B1 гэрчилгээтэй сурагч
- **B1 түвшинд:** B2 түвшний шалгалт өгсөн эсвэл B2 гэрчилгээтэй сурагч
- Герман эх хэлтэй эсвэл өдөр тутмын харилцааны хэл нь Герман, мөн эцэг эхийнх нь аль нэг нь герман эх хэлтэй бол
- 3 наснаасаа хойш Герман хэлтэй орнуудад 6 сар болон түүнээс дээш хугацаагаар тасралтгүй амьдарч байсан бол
- Хилийн чанад дахь Герман ЕБсургуульд сурдаг сурагч
- Хичээлийн болон харилцааны хэл нь голчлон герман хэлээр явагддаг хувийн сургуулийн сурагчид
- 2026 онд Герман улсад хэлний курст хамрагдах тэтгэлэг авсан сурагчид
- Их сургуульд аль хэдийн элсэн суралцаж эхэлсэн бол
- Насанд хүрсэн сурагчид

Худал мэдүүлэг өгсөн оролцогчийн олимпиадад оролцох эрхийг нь цуцлах буюу ялагч болсон, шагналт байранд орсон тохиолдолд тухайн шагналыг хүчингүйд тооцно.



Бүртгэл

NDO 2026-ын бүртгэл тухайн ЕБС-ийн герман хэлний багш нараар дамжин явагдана. Бүрэн гүйцэд бүрдүүлсэн материалаа герман хэлний багш нартаа өгнө үү. Тэд бүртгэлийн материалыг цуглуулан Монгол дахь Гёте-Институтэд өөрийн биеэр эх хувиар нь хүлээлгэн өгөх болно.

Бүртгэлийн материал

- Бүрэн гүйцэд бөглөсөн, эцэг эхийн гарын үсэг бүхий бүртгэлийн маягт
- Олимпиадад оролцох хүсэлт (хамгийн ихдээ 1 нүүр, pdf эсвэл Word формат)
- Хэлний шалгалтын гэрчилгээ (хэрэв байгаа бол)
- Төрсний гэрчилгээний хуулбар
- Гадаад паспортын хуулбар

Бүртгэл хаах хугацаа

Бүртгэл хүлээн авах эцсийн хугацаа: **2026 оны 2-р сарын 27.**
Заасан хугацаанаас хойш ирсэн материалыг **хүлээн авах боломжгүй.**

Урьдчилсан шалгаруулалтын явц

NDO тэмцээний урьдчилсан болон эцсийн шат **2026 оны 3-р сарын 14-нд, Улаанбаатар** хотод болно. Шалгаруулалтад оролцогчид тухайн өдөр бүтэн өдөр чөлөөтэй байх шаардлагатай.

Үйл ажиллагаа болох газрыг тухайн үед зарлах болно.

Улаанбаатар хотоос бусад газраас ирж буй оролцогч нарын аялалын зардлыг зөвхөн баримт эсвэл тасалбарыг үндэслэн буцаан олгоно.

Олимпиад **Унших, Сонсох, Танилцуулга хийх** гэсэн 3 төрлөөр явагдана.

Бэлдэх материал

Олимпиадын Унших болон Сонсох хэсгийн даалгавар дор дурдсан шалгалтад суурилсан:

- Goethe-Zertifikat **A2: Fit in Deutsch**
- Goethe-Zertifikat **B1 für Jugendliche**

Links:

[Übungsmaterialien - Goethe-Institut Mongolei](#)

[Übungsmaterialien - Goethe-Institut Mongolei](#)



Холбоо барих

- Г. Ариунцэцэг (Монгол дахь Гёте-Институтийн сургалтын албаны дарга)
Утас: 95812633 – E-Mail: Ariuntsetseg.Ganbold@goethe.de
- Б. Бэрцэцэг (Монгол дахь Гёте-Институтийн ПАШ төслийн зохицуулагч)
Утас: 95812633 – E-Mail: bertsetseg.bumaakhuu@goethe.de
- Моника Эггер (Хилийн Чанад дахь Германы ЕБ-ын асуудал хариуцсан төв газрын Монгол дахь Герман хэлний зөвлөх)
Утас: 88201986 – E-Mail: ulanbator@auslandsschulwesen.de